

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

**2014 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ**

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
2014 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНД ХИЙСЭН СИСТЕМЧИЛСЭН  
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2015.03.12

Улаанбаатар

УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн 05 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны жилийн ажлын тайланд Хорооны Ажлын албаны даргын 2015 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 33 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг үнэлгээ хийлээ.

Үнэлгээг Хууль зүйн яамнаас боловсруулан гаргасан “Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу дотоодын үнэлгээний хэлбэрийг сонгож хийсэн болно.

Санхүүгийн зохицуулах хороо нь 2014 онд “Монгол улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл” болон “Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод сууриссан үндэсний хөгжлийн цогц бодлого”-д тусгасан зорилтуудын холбогдох заалт, УИХ-ын тогтоол, Байнгын хорооны хуралдааны тогтоол, тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгавар, Хорооны 2012 оны 4 дүгээр сарын 24-ны өдрийн 117 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны 2012-2016 оны үйл ажиллагааны стратеги зорилт”-ын хүрээнд 204 ажил төлөвлөн 98.3 хувийн биелэлттэй хийж гүйцэтгэсэн байна.

Тайлант хугацаанд Хорооны төлөвлөгөөний биелэлтийн явцын хяналтыг хэрэгжүүлж, улирал бүр гүйцэтгэлийг нэгтгэн Хорооны удирдлагад танилцуулж байжээ.

Санхүүгийн зохицуулах хорооны дээрх Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг тооцох ажлыг Хорооны ажилтнууд болон мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг хэлбэрээр 2 дахь удаагаа 2014 оны 4 дүгээр сард зохион байгуулсан байна.

## **НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛ БОЛОН ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ**

### **1. Байгууллагын зохион байгуулалтын бүтэц, чиг үүрэг.**

Хороо 2014 онд Үнэт цаасны газар, Даатгалын газар, Бичил санхүүгийн газар, Тамгын газар болон Дотоод хяналтын хэлтэс, Компанийн засаглалын хөтөлбөрийг хэрэгжүүлэх алба гэсэн нэгжүүдтэй, Ажлын албаны 122 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулсан байна.

Хорооны бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт болон дээрх нэгжүүдийн чиг үүргийг Хорооны 2011 оны 172 дугаар тогтоолоор баталсан бөгөөд Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай, Хөдөө аж, ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай, Жолоочийн даатгалын тухай, Зээлийн мэдээллийн тухай, Зээлийн батлан даалтын сангийн тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай, Малын индексжүүлсэн даатгалын тухай зэрэг хуулиуд шинээр батлагдаж Хорооны үйл ажиллагааны хамрах хүрээ болон зохицуулалтад хамрагдах байгууллагуудын тоо эрс өссөн, зах зээлийн үйлчлэх хүрээ нэмэгдсэнтэй холбоотойгоор цаашид байгууллагын бүтэц зохион байгуулалт, чиг үүргийг боловсронгуй болгох, ажиллах хүчний нөөцийг оновчтой, зөв хуваарилах, ажлын байрны тодорхойлолтыг холбогдох хууль, журамд нийцүүлэн шинэчлэх шаардлагатай.

### **2. Хэрэгжүүлж буй чиг үүргийн агуулга.**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу Хорооны чиг үүргийн хэрэгжилтийг гаргалаа.

Тайлангийн хугацаанд зохицуулалтын салбарын хэмжээнд хэрэгжиж буй Монгол Улсын 9 хууль, бодлогын 4 баримт бичиг, дээд газрын 13 тогтоол, шийдвэрт заасан нийт 99 заалтад хяналтын карт хөтлөн хэрэгжилтийг хангуулан ажилласан бөгөөд холбогдох журамд заасан хугацаанд биелэлтийг гаргаж тухай бүр УИХ-ын Тамгын газарт хүргүүлсэн байна.

Мөн УИХ-ын гишүүдээс ирүүлсэн санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн талаарх мэдээг нэгтгэн УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2010 оны 50 дугаар захирамжийн дагуу улирал бүр хүргүүлж ажиллажээ.

Тайлант онд тус Хорооны 21 удаагийн хуралдаанаар 473 асуудал хэлэлцэж, холбогдох шийдвэрүүдийг гаргасан нь өмнөх онтой харьцуулахад хэлэлцсэн асуудлын тоо 95 буюу 16.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2006-2014 онуудад Хорооны 174 удаагийн хуралдаанаар 3345 асуудлыг хэлэлцэн холбогдох шийдвэрүүдийг гаргаж, хэрэгжилтийг бүртгэл хяналтын карт хөтлөн хяналт тавьж ажилласан байна.

2014 онд тусгай зөвшөөрөл шинээр олгох, сунгах, сэргээх, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой 311 шийдвэр гаргасан нь өмнөх оноос 22.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2013 онд Хорооны хяналт, зохицуулалтад 980 хуулийн этгээд, 4356 иргэн хамрагдаж байсан бол 2014 онд 1108 хуулийн этгээд, 4752 иргэн хамрагдаж зохицуулалттай этгээдийн тоо 9.8 хувиар өссөн бөгөөд хяналт, шалгалтын ажлын төлөвлөгөөний дагуу нийт 292 зохицуулалтын байгууллагын үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалтыг хэсэгчилсэн, иж бүрэн болон хамтарсан хэлбэрээр хийжээ.

Тайлант хугацаанд зохицуулалтын байгууллагуудын санхүүгийн тайлан, үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг Fina системээр хүлээн авч зайны хяналт шалгалтыг 1725 удаа хийж дүгнэлт гаргасан байна.

Зохицуулалтад хамрагдах хуулийн этгээдийн үйл ажиллагаанд төлөвлөгөөний дагуу зайны болон газар дээрх хяналт, шалгалтыг хэрэгжүүлж, газар дээрх шалгалтад нийт хуулийн этгээдийн 26.5 хувийг хамруулж, хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд албан шаардлага хүргүүлэн хугацаатай үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг хангуулан ажилласан бөгөөд Улсын байцаагчдаас 153.4 сая төгрөгийн торгууль, шийтгэврийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлж ажиллажээ.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй зохицуулалтын байгууллага, тэдгээрийн салбарт газар дээрх хяналт, шалгалт хийх болон сургалт, семинар зохион байгуулах ажлыг Хорооны орон нутаг дах төлөөлөгчдөөр дамжуулан хуваарийн дагуу зохион байгуулсан байна.

Цаашид УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны 2011 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 28 дугаар хурлын тэмдэглэлд "... Хөрөнгийн зах зээлийн хөгжлийг эрчимжүүлэх шаардлагатай уялдуулан СЗХ болон түүний дэргэдэх Хяналтын зөвлөлийн эрх, үүргийг өргөтгөх, бие даасан байдлыг бэхжүүлэх, ялангуяа Хорооны төлөөллийг орон нутагт орон тооны болгох, төсөв санхүүжилтийн бие даасан байдлыг нь хангах зэрэг чиглэлээр СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хуульд зарим нэмэлт, өөрчлөлт өруулах асуудлыг судлан боловсруулах", 2013 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 30 дугаар хурлын тэмдэглэлд "... Банк бус санхүүгийн үйл ажиллагааг алслагдсмал орон нутгийн иргэдэд хүргэх хүртээмж хязгаарлагдмал хэвээр байгааг анхааралдаа авч, тэдгээрийн үйлчилгээний хүрээг тэлэх зохицуулалтын оновчтой бодлого боловсруулж, орон нутагт тохирсон банк бус санхүүгийн үйлчилгээний шинэ загвар бүтээгдэхүүн нэвтрүүлэх, бичил санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга механизмыг сайжруулах, Төв банктай энэ чиглэлээр хамтран ажиллах" гэж тус тус заасан, мөн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа зохицуулалтын байгууллагууд,

тэдгээрийн салбарын тоо эрс өсч байгааг харгалзан Хорооны тесөвт шаардагдах зардлыг тусгуулан шийдвэрлүүлэх нь зүйтэй.

Тайлант онд Хороо иргэдээс 386 өргөдөл, байгуулагаас 9799 албан бичиг хүлээн авч, 5580 албан бичиг гадагш явуулж, бичиг хэргийн нийт эргэлт 15758 байсан нь 2013 онтой харьцуулахад 10.9 хувиар өссөн узүүлэлт байгаа бөгөөд шийдвэрлэвэл зохих асуудлын тоо тогтмол өсч, бичиг хэргийн эргэлт эрс нэмэгдэж байгааг харгалзан харьцуулсан судалгаа хийж бичиг хэргийн ажилтны орон тоог нэмж ажиллуулах шаардлагатай.

Олон нийттэй ил тод, нээлттэй харилцааг бий болгох, хууль тогтоомжийг сурталчлах, мэдээллээр хангах, иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх болон санхүүгийн зах зээлийн сургалт, сурталчилгааг сайжруулах, хүртээмжтэй болгох, Хорооны үйл ажиллагааг сурталчлах ажлын хүрээнд 31 телевиз, 2 радио, 2 мэдээллийн агентлаг, өдөр тутмын 12 сонин, 14 вэб сайтад давхардсан тоогоор 109 сэдвээр 391 удаагийн ярилцлага өгсөн байна.

### 3. Үйл ажиллагаа явуулж буй байдал.

Санхүүгийн зохицуулах хороо нь 2014 онд 4 газар, 18 хэлтэстэй нийт 204 ажил хийхээр төлөвлөсөн бөгөөд төлөвлөгөөний биелэлт 98.3 хувьтай байна. Төсвийн хүрэлцээ хангалтгүй, санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлээгүйн улмаас төлөвлөгөөнд тусгагдсан улсын байцаагч нарын сургалт хийгдээгүй, боловсруулалт, танилцуулга бүрэн хийгдэж дууссан Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийг УИХ-д өргөн барьсан боловч төлөвлөсөн хугацаанд батлагдаагүй байна.

Тайлант онд Хорооны хурлын 467 тогтоол, Хорооны даргын 351 тушаал, Улсын Ерөнхий байцаагчийн 20 тушаал, Ажлын албаны даргын 248 тушаалаар нийт 1086 асуудлыг шийдвэрлэсэн байна.

2014 онд Хорооны ажилтнуудаас үйл ажиллагаа хийгдэж дууссан 1409 хадгаламжийн нэгжийг архивт шилжүүлсэн бөгөөд оны эцсийн байдлаар Хорооны архивт 8888 хадгаламжийн нэгж хадгалагдаж байна. Орон байрны хүрэлцээ муугаас шалтгаалан байгууллагын архив, бичиг баримтын хадгалалт стандартын дагуу зай талбайд хадгалагдахгүй байгааг цаашид анхаарахыг өнгөрсөн жилийн үнэлгээний тайланд тусгасан байсан бөгөөд 2014 онд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд Хорооны архивын хадгалалт хамгаалалт сайжирч, сан хөмрөгийн өрөөг 2 болгон зориулалтын нягтаруулсан 32 шүүгээг суурилуулж архивын баримтыг байршуулсан байна.

2014 оны жилийн эцсийн байдлаар Хороо эрхлэх асуудлын хүрээнд төрийн 6 байгуулага, 9 мэргэжлийн холбоод, 5 төрийн бус байгууллага, 2 хэвлэл мэдээллийн байгууллага, 6 гадаадын байгууллагатай хамтран ажиллах санамж бичиг байгуулсан бөгөөд зарим холбоод болон байгууллагатай хамтран ажиллах чиглэлд ахиц гарч байгаа хэдий ч, зарим чиглэлд хангалтгүй байгаад анхаарч, дээрх санамж бичгүүдийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар төлөвлөгөө гарган биелэлтийг тухай бүр тооцож ажиллах шаардлагатай гэж үзлээ.

Хорооны цахим хуудсын хэвийн найдвартай ажиллагааг хангаж, мэдээ, мэдээллийг тогтмол шинэчлэн англи болон монгол хувилбарууд дээр хөтлөн явуулж байна.

Цаашид мэдээллийн технологийн сургалт явуулах, сүлжээний тоног төхөөрөмж, мэдээлэл, мэдээллийн сан, бусад системийн аюулгүй байдлыг хангах, "Fin-A" системийн технологи, үйл ажиллагаа, арга зүйн ба албажуулалтын хүрээг сайжруулах, Хорооны дотоод цахим хуудсыг ажлын ачааллыг багасгах чиглэлд оновчтой шийдэл байдлаар боловсронгуй болгох зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэх шаардлагатай.

Хорооны ажлын төлөвлөгөө, тайланд өгөх үнэлгээг боловсронгуй болгох, төлөвлөгөө, тайлангийн боловсруулалтыг сайжруулах, үр дүнд суурилсан чиглэлээр боловсруулах, үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэх, хяналтыг бүрэн хэрэгжүүлэх зорилгоор үйл ажиллагааны хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан тусгайлсан нэгжийг байгуулах шаардлагатай.

#### **4. Ажилтнуудын талаарх мэдээлэл.**

Төрийн албан хаагчийг мэргшүүлэх, чадавхжуулах ажлын хүрээнд 2014 онд гадаадын их дээд сургуульд магистрын зэрэг олгох сургалтад 12, дотоодын их дээд, сургууль, академид 3 ажилтныг тус тус суралцуулснаас гадна Хорооны нийт ажилтнуудад Монгол хэлний зөв бичгийн дүрэм, найруулга зүйн сургалт, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаалд анх шинээр орж байгаа /гэрээт/ 34 ажилтанд “Төрийн алба, түүний мөн чанар, төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр, Хорооны удирдах албан тушаалд ажиллаж буй 24 ажилтанд “Төрийн албаны шинэтгэлийн бодлого, зөрчлийн удирдлага”, ”Үр дүнгийн гэрээг үнэлэх нь” сэдвээр, Удирдах албан тушаалын 42 ажилтанд “Байгууллагын менежментийн хандлага” “Манлайлал, багийн ажиллагаа” сэдвээр, Ахлах албан тушаалын 22 ажилтанд “Төрийн албан хаагчийн ажлын байранд тавигдах шаардлага”, “Ажлын арга барил, баримтлах зарчим” сэдвээр холбогдох сургалтуудыг тус тус зохион байгуулсан бөгөөд Люксембургийн Вант улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Санхүүгийн салбарыг бэхжүүлэх болон сургалтын төсөл”-ийн хүрээнд англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх сургалтуудыг үе шаттайгаар үргэлжлүүлэн зохион байгуулсан байна.

2014 оны жилийн эцсийн байдлаар Хорооны хэмжээнд төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвтэй 56 албан хаагч ажиллаж байна.

Боловсролын түвшингээр авч үзвэл доктор 3, магистр 44, бакалавр 64, тусгай дунд боловсролтой 2, бүрэн дунд боловсролтой 2, бүрэн бус дунд боловсролтой 1 ажилтан байна.

Хорооны ажилтнуудын 58.6 хувь нь санхүү эдийн засгийн мэргэжилтэй, 16.4 хувь нь эрх зүйч, 25 хувь нь бусад мэргэжлийнх байгаа бөгөөд төрийн албанад 5-аас дээш жил ажилласан ажиллагсдын тоо нийт ажилтны 38 хувийг эзэлж байгаа тул төрийн алба тогтвортой, мэргэшсэн байх зарчмыг хангаж ажиллах нь зүйтэй.

Цаашид хүний нөөцийн талаар баримтлах бодлого /хөтөлбөр/-ыг шинэчлэн боловсруулж, хуульд заасны дагуу ажилтнуудыг тогтвортруулж ажиллуулах, төрийн албаны мэргэшсэн баг бүрдүүлэх, ажилтнуудын нийгмийн асуудлыг шат дараатай шийдвэрлэхэд анхаарч ажиллах шаардлагатай.

#### **5. Эрх зүйн болон бусад орчин нөхцөл.**

2014 онд холбогдох журам, зааврыг шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хүрээнд нийт 48 журам, заавар боловсруулан гаргасан нь өмнөх жилийнхтэй харьцуулахад 20 хувиар буурсан үзүүлэлт гарч байна.

2014 онд Хороо нь Компанийн тухай хууль, Малын индексжуулсэн даатгалын тухай хууль, Эрүүгийн хууль, Хохирлыг эргэн төлөх нөхцөлөөр барагдуулах тухай хууль, Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хуулиудыг шинээр боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах, санал дүгнэлт өгөх ажлын хэсэгт орж ажилласан бөгөөд 15 хуульд судалгаа хийж санал хүргүүлсэн байна.

2014 оны байдлаар Хорооны үйл ажиллагаанд шууд хамааралтай дараах хуулиудын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд: Валютын зохицуулалтын тухай, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай, Хоршооны тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай, Даатгалын тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай, Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн биржийн тухай, Жолоочийн даатгалын тухай, Компанийн тухай, Зээлийн мэдээллийн тухай, Хадгаламж зээлийн хоршооны тухай, Зээлийн батлан даалтын сангийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай, Хөрөнгө оруулалтын тухай зэрэг хуулиуд болно.

Дээрх хуулиудыг дагалдан гарсан 168 журам, заавар, аргачлал, дүрмийг мөрдөн ажиллаж байгаа бөгөөд салбараар нь ангилж авч үзвэл, Бичил санхүүгийн салбарын зохицуулалтын чиглэлээр 42 журам, Үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын чиглэлээр 43 журам, Даатгалын салбарын зохицуулалтын чиглэлээр 67 журам, Эрсдлийн үнэлгээ судалгаа, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний чиглэлээр 16 журмыг тус тус мөрдөн ажиллаж байна.

Цаашид шинээр буюу шинэчлэн батлагдсан хуулиудтай дагалдан гарах журам, заавруудыг боловсруулах, зарим журам зааврыг боловсронгуй болгох, өөрчлөх шаардлагатай.

## 6. Ажилтнуудын ажлын ачаалал.

Хорооны үндсэн чиг үүргийг хариуцан ажиллаж байгаа нэгжүүдэд нийт ажилтнуудын 62 хувь нь ажиллаж байгаа бөгөөд Бичил санхүүгийн газрын нэг ажилтан 26-34 зохицуулалтын байгууллага, Үнэт цаасны газрын нэг ажилтан 27-43 зохицуулалтын байгууллага тус тус хариуцдаг, нэг ажилтан жилд 127 албан бичиг, өргөдөл гомдолтой танилцаж 81 албан бичигт хариу хүргүүлдэг, Хорооны хуралд 8-27 асуудал боловсруулж танилцуулдаг, 40 орчим хууль журмын хэрэгжилтийг хангаж ажилладаг, жилд 5 удаа сургалт, семинарт хамрагддаг, газар дээрх хяналт шалгалтын ажилд 3 удаа оролцож тайлан гаргадаг, Бодлогын хэлтсийн ажилтнуудын хувьд 3-4 хууль, журмын төслийг дангаар болон хамтарч боловсруулдаг зэрэг дундаж тоон үзүүлэлтүүд гарч байгаа тул зохицуулалтын байгууллага хариуцсан нэгжийн нэг ажилтанд ногдох ажлын ачаалал “Их” гэсэн үзүүлэлттэй байна.

Дээрх үзүүлэлтүүдийг салбараар авч үзвэл Бичил санхүүгийн салбар болон Үнэт цаасны салбар хариуцсан ажилтнуудын хувьд ажлын ачаалал “Их” буюу Хорооны дундаж үзүүлэлтээс дээгүүр байгаа тул цаашид ажлын ачаалал, боловсон хүчний нөөцийн хувиарлалтыг оновчтой болгоход анхаарах шаардлагатай.

## 7. Төсөв, хөрөнгө.

УИХ-ын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан Санхүүгийн зохицуулах хорооны дүрмийн 5.4-т “Хороо өөрийн орлогыг аажмаар нэмэгдүүлж, төсвийн санхүүжилтийг бууруулах зарчмыг баримтална” гэж заасан бөгөөд өнгөрсөн хугацаанд дээрх зарчмын хэрэгжилтийг жил бүр хангаж ажиллан /хүснэгт-1/ 2014 оны орлогын төлөвлөгөөг 508,9 сая төгрөгөөр давуулан биелүүлж, батлагдсан төсвийг 3.8 хувь буюу 92 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Хүснэгт-1 /сая төгрөгөөр/

Он	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014
Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын дүн	60.3	595.0	567.3	417.2	692.5	960.1	884.9	1,536.4	1,308.9

Дээрх хүснэгтээс харахад төсвийн орлого жил бүр өссөн үзүүлэлттэй байгаа нь зохицуулалтын байгууллагуудын тоо жил бүр нэмэгдсэн, Хорооны хяналт, зохицуулалт сайжирч байгааг харуулж байна.

Хорооны жил бүрийн улсын төсөвт төвлөрүүлж буй орлого буюу “Тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс төвлөрүүлсэн зохицуулалтын үйлчилгээний хөлс”-ийг санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хөгжүүлэх чиглэлд зарцуулах талаар харилцагч, үйлчлүүлэгчдээс гаргасан удаа дараагийн санал, хүсэлтийг судалж, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах талаар санал боловсруулан шийдвэрлүүлэх шаардлага зүй ёсоор гарч байгаад онцгой анхаарч ажиллах шаардлагатай.

Хороо төсвийн орлогын төлөвлөгөөг жил бүр давуулан биелүүлж байгаа боловч санхүүгийн жилийн төсвийг батлахдаа хөрөнгө оруулалттай холбоотой саналыг удаа дараа

шийдвэрлэдэггүй, урсгал зардлыг төсвийн тодотголоор байнга танаж, хасч байгаагийн улмаас ажилтнуудын албан хэрэгцээний нийт компьютерийн 75 хувь элэгдлээ бүрэн нөхөж ашиглалтын хугацаа дууссан, 52 хувь нь хүчин чадлын хувьд шаардлагад нийцэхгүй, ажилтнуудын 20 хувь нь файлын шүүгээгүй, зарим ажилтнууд түрээсийн байранд үйл ажиллагаа явуулдаг, хэт олноороо суудаг, өрөө тасалгааны хангамж, хүрэлцээ туйлын муу, батлагдсан стандартаас доогуур үзүүлэлттэй байгаа зэрэг нь ажлын үр дүнд сөргөөр нөлөөлж, эрсдэл дагуулж болзошгүй байна.

УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны 2011 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 28 дугаар хурлын тэмдэглэлд “...Хөрөнгийн зах зээлийн хөгжлийг эрчимжүүлэх шаардлагатай уялдуулан СЗХ болон түүний дэргэдэх Хяналтын зөвлөлийн эрх, үүргийг өргөтгөх, бие даасан байдлыг бэхжүүлэх, ялангуяа Хорооны төлөөллийг орон нутагт орон тооны болгох, төсөв санхүүжилтийн бие даасан байдлыг нь хангах зэрэг чиглэлээр СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хуульд зарим нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судлан боловсруулах”, “Хорооны үйл ажиллагаанд шаардлагатай байгаа байр, тоног төхөөрөмж, иргэд, олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх сургалтын нэгдсэн төвийн барилга, санхүүгийн мэдээллийн технологийн шинэчлэл, боловсон хүчний сургалт, дадлагажилт зэрэг асуудлуудад шаардагдах хөрөнгийн тооцоо судалгааг гаргаж 2011 оын төсвийн тодотголд болон 2012 оны төсөвт тусгуулах талаархи саналаа Засгийн газар, Улсын Их хуралд ирүүлж шийдвэрлүүлэх” гэж заасны дагуу шаардагдах төсвийн тооцооллыг хийж, холбогдох тайлбарын хамт эрх бүхий байгууллагуудад удаа дараа хүргүүлсэн боловч шийдвэрлэхгүй өнөөг хүрч байгаа тул цаашид байгууллагын хэвийн үйл ажиллагааг явуулах нөхцлийг бүрдүүлж ажиллахад онцгой анхаарах шаардлагатай.

## **ХОЁР. 2014 ОНД ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ГАРСАН АХИЦ, ӨӨРЧЛӨЛТ**

Ажлын хэсгээс тайлант онд Хорооны үйл ажиллагаанд гарсан томоохон ахиц, өөрчлөлтийг өнгөрсөн онтой харьцуулах байдлаар гаргалаа. Үүнд:

### **1. Бичил санхүүгийн салбарын:**

-Бичил санхүүгийн салбарын харилцагчдын тоо сүүлийн 3 жилд 1,5 дахин нэмэгдэж, 2014 онд Бичил санхүүгийн байгууллагуудын тоо 32,9 хувиар, салбарын эдийн засгийн үзүүлэлтүүд 30 хувиар, хөрөнгийн хэмжээ 29,3 хувиар, салбарын ашигт ажиллагаа, хөрөнгийн өгөөж 25 хувиар тус тус өсч, салбарын нийт актив 588,5 тэрбум төгрөг болж салбарын ашигт ажиллагаа өмнөх оноос 24,5 хувиар нэмэгдсэн нь байгууллагуудын тоо, актив хөрөнгийн өсөлт, зээлийн чанарын өсөлт сайжирсан, үйл ажиллагааны цар хүрээ, харилцагчдын тоо нэмэгдсэнтэй холбоотой байна.

-Банк бус санхүүгийн байгууллагуудыг Монголбанкны гадаад валютын дуудлага худалдаанд оролцох боломжийг нээж Худалдаа хөгжлийн банк, Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо, валютын арилжааны эрхтэй Банк бус санхүүгийн байгууллагууд хамтран “Хамтын ажиллагааны гурван талт гэрээ”-г байгуулсан байна.

-Хадгаламж, зээлийн хоршоодын үйлчилгээний нэр төрөл, санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийг Нийслэлийн захирагчийн албатай хамтран хэрэгжүүлэх ажлын хүрээнд 35 Хадгаламж, зээлийн хоршоонд 2,1 тэрбум төгрөгийн бага хүүтэй санхүүгийн эх үүсвэрийг олгосон байна.

-Хадгаламж, зээлийн хоршоодын сургалтын модулийг боловсруулж, 1234 удирдах болон сонгуулжт ажилтанг хамруулсан бүсчилсэн сургалтыг зохион байгуулж, нийт 136 /93,5 хувь/ Хадгаламж, зээлийн хоршоодод чадавхийн үнэлгээг хийсэн байна.

-Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, Хадгаламж, зээлийн хоршоодын талаарх иргэдийн итгэлийг сэргээх, сайн туршлагыг түгээх зорилгоор “Саятан болгох дамжаа” телевизийн олон ангит уран сайхны кино бүтээж, баримтат кино, нэвтрүүлэг

бэлтгэн олны хүртээл болгосноос гадна иргэдэд зориулсан салбарын бодлогын баримт бичгүүдийг нэгтгэсэн гарын авлага гаргасан байна.

## 2. Даатгалын салбарт:

-Даатгалын салбарын нийт орлого 2.2 дахин /3.2 тэрбум/, суурь үзүүлэлтүүд 20 гаруй хувиар, даатгалын мэргэжлийн оролцогчид 43 хувиар, Албан журмын даатгалын хураамжийн хэмжээ 33 хувиар, нөхөн төлбөр 43 хувиар, сайн дурын даатгал болох хөрөнгийн даатгал 26 хувиар, ачааны даатгал 76 хувиар, эрүүл мэндийн даатгал 108 хувиар, даатгалын нөөц сангийн хэмжээ 66.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеийнхээс 15 хувиар, гадагш шилжүүлсэн давхар даатгалын хураамжийн хэмжээ 31.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 20 хувиар, даатгалын хохирлын харьцаа 43 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 1 пунктээр тус тус өссөн нь арилжааны даатгалын цар хүрээ, хүртээмж нэмэгдсэн, иргэдийн даатгалын талаарх ойлголт сайжирч байгааг харуулж байна.

-УИХ-аар Малын индексжуулсэн даатгалын тухай хууль батлагдаж малчин иргэдийн амжиргааны гол үндэс болох малыг даатгалд хамруулах эрхзүйн үндэс бүрдсэн. Мөн Монгол Улсад анхны давхар даатгалын компани байгуулж үндэсний давхар даатгалын чадавхийг бүрдүүлэх, олон улсын давхар даатгалын зах зээлтэй харьцах боломжийг нээсэн байна.

-“Хүртээмжтэй даатгал” сэдэвт олон улсын форумыг анх удаа зохион байгуулж гадаадын 10 гаруй улс орны даатгалын зохицуулагчдыг оролцуулан туршлага, мэдлэгээ солилцсон байна.

-Канадын “Торонто центр” сургалтын байгууллага, Энэтхэгийн “Даатгалын институт”-тэй хамтарсан сургалтууд зохион байгуулж, даатгалын андеррайтингийн гарын авлагыг гаргасан байна.

-Хадгаламж, зээлийн хоршоо даатгалын төлөөлөгчөөр ажиллах эрх зүйн үндсийг бүрдүүлснээр даатгалын хүртээмжийг нэмэгдүүлж, орон нутгийн иргэд хоршоогоор дамжин даатгалд хамрагдах, даатгалын ойлголт мэдлэг олж авахад ихээхэн тус нэмэр болох юм.

## 3. Үнэт цаасны зах зээлийн салбарт:

- Зах зээлийн үнэлгээ 1442.66 тэрбум төгрөг болж 227.87 тэрбум төгрөгөөр буюу 13.6 хувиар, ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 15264.58 нэгж, доод үзүүлэлт 14475.2 нэгж, дундаж үзүүлэлт 14832.98 нэгж, хаалтын ханш 14854.24 нэгж болж 1447.57 нэгжээр буюу 8.9 хувиар, хувьцааны арилжааны үнийн дүн 73.4 тэрбум төгрөгөөр буюу 75.2 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

- Монгол улсын иргэд данс нээлгэх тоон үзүүлэлт өссөн боловч гадаадын иргэн, аж ахуйн нэгжийн данс нээлгэх тоон үзүүлэлт буурсан байна.

- 2014 оны 11 дүгээр сараас эхлэн Засгийн газрын жижиглэнгийн бонд Монголын хөрөнгийн биржээр арилжаалагдах болсноор Засгийн газрын бонд олон нийтэд хүртээмжтэй болж, иргэдийн хөрөнгийн зах зээлийн ойлголтыг сайжруулахад ахиц гарсан байна.

- Орон сууцны моргейжийн урт хугацаат зээлийг үнэт цаасжуулах буюу үл хөдлөх хөрөнгийн хоёрдогч зах зээлийг хөрөнгийн зах зээлтэй холбох, үл хөдлөх хөрөнгийн анхдагч зах зээлийг дэмжих ажлын хүрээнд 881,5 тэрбум төгрөгийн моргейжийн зээлээр баталгаажсан үнэт цаас/ABS/-ыг бүртгэж, арилжаалах зөвшөөрлийг Хорооноос олгож хөрөнгийн зах зээл дээр шинэ бүтээгдэхүүн үүссэн байна.

-Хороо 2014 оны 6 дугаар сард Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагын олон талт хамтын ажиллагааны гишүүнээр нэгдэн орж 200 гаруй гишүүн байгууллагатай мэдээлэл солилцох, хамтран ажиллах, үйл ажиллагааны туслалцаа авах боломжтой болсон нь хөрөнгийн зах зээлийн цаашдын нь хөгжилд чухал үйл явдал болсон байна.

-Японы Санхүүгийн үйлчилгээний хороотой харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах талаар хоёр байгууллагын удирдлагын уулзалтыг Монгол улсад зохион байгуулж,

Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагын /ЛСА/ санхүүжилтээр Үнэт цаасны зах зээлийн чадавхийг бэхжүүлэх төслийг 2014-2017 он хүртэл 3 жилийн хугацаатайгаар хэрэгжүүлэхээр болсон байна.

-Мэргэжлийн томоохон хөрөнгө оруулагчдыг бий болгох, тэдний хөрөнгийг найдвартай хадгалах, эрх ашгийг хамгаалах нөхцлийг бүрдүүлэх ач холбогдол бүхий хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллага болох кастодианы үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчинг бүрдүүлж, тусгай зөвшөөрлийг 2 банкинд олгосон байна.

-Хорооноос 2014 оны 9 дүгээр сард Азийн хөгжлийн банктай хамтран Ази номхон далайн бүс нутгуудын төлөөлөл оролцсон “Хөрөнгийн оруулалтын сангийн хяналт, зохицуулалт” сэдэвт олон улсын семинарыг амжилттай зохион байгуулсан байна.

-Үнэт цаасны зах зээлд оролцогчдыг ижил мэдээллээр хангах зорилгоор Тайваны “Грейт бирж”, Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа ХК-уудад зориулсан сургалтуудыг тус тус зохион байгуулж, иргэдэд зориулж Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, тогтоомжийн эмхэтгэл, нэр томъёоны тайлбар толь, гарын өвлага, брошур, сэтгүүлийн тусгай дугаар, ном зэргийг гаргасан байна.

Цаашид Хорооны зүгээс үнэт цаасны зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, дэд бүтцийн уялдаа холбоог сайжруулж, томоохон мэргэжлийн хөрөнгө оруулагчид болон шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, эрсдэлд суурилсан хяналт, шалгалтыг нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр бүтэц, чиг үүрэгт өөрчлөлт оруулан ажиллаж байна.

#### **4. Хорооны дотоод үйл ажиллагаанд:**

- Хорооны албан хэрэг хөтлөлтөд “Бүтээмж -2014“ програмыг нэвтрүүлсэн байна.
- Хорооны дотоод интранет сайтыг шинээр нээж, ажилтнуудад мэдээллийг цахим хэлбэрээр шуурхай хүргүүлдэг болсон байна.
- Хорооны архивт захирамжлалын баримт бичгүүдээр “Цахим сан” үүсгэсэн байна.
- Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхийн нэгдсэн бүртгэлийн мэдээллийн сан бий болгох бэлтгэл ажлын хүрээнд “Програмын системийн даалгавар” боловсруулсан байна.

#### **ГУРАВ. САНАЛ, ДҮГНЭЛТ**

Тайлант онд Хороо нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах нэгдсэн бодлого боловсруулах, зохицуулалтад хамрагдах байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах, хянах, иргэд, хөрөнгө оруулагчид, үйлчлүүлэгчдийг мэдээллээр хангах, сургах чиглэлээр тавьсан зорилтуудаа бүрэн хангаж ажилласан байна.

Цаашид ажлын хүртээмж, чанарыг дээшлүүлэх чиглэлээр анхаарвал зохих асуудлаар ажлын хэсгээс дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

- Нэг. Эрх зүйн орчныг бүрдүүлэх, уян хатан бодлого баримтлах:**
  - Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийг УИХ-аар батлуулах;
  - Хадгаламж, зээлийн хоршоодын гишүүдийн хадгаламжийг хадгаламжийн даатгалд хамруулах бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
  - Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах, зах зээлийн хөгжлийн өнөөгийн түвшинд нийцүүлэх, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог сайжруулах;
  - Хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээл болон бичил санхүүгийн салбарын хөгжлийн загвар боловсруулах;
  - Хувийн тэтгэврийн сангийн эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
  - Бараа, түүхий эдэд суурилсан санхүүгийн үүсмэл хэрэгслийг арилжаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

-Санхүүгийн зах зээл, түүний дотор хөрөнгийн зах зээлийн хөгжлийн дунд болон урт хугацааны стратегийн баримт бичгийг УИХ-аар батлуулах.

**Хоёр. Зах зээлийн хөгжлийг дэмжих:**

-Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олгох зохицуулалтыг хялбаршуулах, тоог бууруулах;

-Эрсдэлд суурилсан хөрөнгө /RBC/, Эрсдэлд суурилсан хяналтын /RBS/ тогтолцоонд шилжих, зах зээлийн судалгаанд үндэслэсэн харилцагчдын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх хяналтын тогтолцоог бүрдүүлэх;

-Зах зээлийн дэд бүтцийг сайжруулах, хөрөнгө оруулагчдын хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, цар хүрээг тэлэх, оролцогчдын уялдааг хангах, мэдлэгийн түвшинг адилтгах;

-Зохицуулалттай этгээдээс төлөх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг санхүүгийн чадавхид нийцүүлэн үндэслэл бүхий тогтоох;

-Бичил санхүүгийн байгууллагуудын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, төсөл хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэх;

-Хөрөнгийн биржийг гадаад, дотоодын хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн байгууллагууд болон биржийн гишүүн брокерийн компаниудад тодорхой бодлогоор хувьчлах;

-Засгийн газрын бондыг Монголбанкаар арилжаалж байгаа өнөөгийн байдлыг өөрчилж, Засгийн газрын бондыг бүхэлд нь /жижиглэнгийн бондоос гадна/ зөвхөн Хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд арилжаалдаг болгох;

-Үнэт цаасны зах зээлийн арилжаанд томоохон мэргэжлийн хөрөнгө оруулагчид болох даатгалын компаниуд болон бусад сангуудын хөрөнгө оруулах сонирхлыг нэмэгдүүлэх.

**Гурав. Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, үйл ажиллагааны эредлийг бууруулах:**

1. Ажлын байрны зай, талбайг стандартад нийцүүлэх, ажилтнуудын техник, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшлын бодит хэрэгцээ шаардлагыг судалж төсвийн санал боловсруулах, санхүүжилтийн бусад эх үүсвэрийг судлах;

2. Хүний нөөцийн талаар баримтлах бодлогын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах, шилдэг туршлагыг судалж нэвтрүүлэх;

3. Энэхүү тайланд дурьдагдсан бусад асуудлуудыг анхааралдаа авч бодит үр дүнд хүрэх.

## **АЖЛЫН ХЭСЭГ**